ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДУА-2026/104/НА-СТА-ТШЗ**


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Азуре Хүлүг Аудит ХХК
Утас: 70110090
Цахим хаяг: audit@azure.mn


Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2026 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 8
3.1 Төлбөрийн акт ..... 8
3.2 Албан шаардлага ..... 8
3.3 Зөвлөмж ..... 9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 10


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.24 № 46

танай ______________ -ны № ______________ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЦОГТ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
А.МӨНХБААТАР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 108,206.4 мянган төгрөгөөр өссөн байна. Мөн балансаас балансt хөрөнгө шилжүүлсэн авсантай холбоотой үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 44,975.2 мянган төгрөгөөр өсжээ. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж

4826050223

үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 92.0 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **200,289,828.14** | **511,468,933.22** |
| 31200 | Банканд байгаа бэлэн мөнгө | 200,289,828.14 | 511,468,933.22 |
| 31210 | Төгрөг | 200,289,828.14 | 511,468,933.22 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 188,891,893.14 | 511,468,933.22 |
| 31218 | Ахмадын сангийн харилцах | 11,397,935.00 | - |
| **33** | **АВЛАГА** | **801,280.00** | **8,533,215.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 185,280.00 | 185,280.00 |
| 33101 | Цалингийн авлага | 185,280.00 | 185,280.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 8,347,935.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **73,015,273.83** | **98,175,261.65** |
| 35100 | Түүхий эд материал | 18,335,210.40 | 42,845,870.60 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 18,083,410.40 | 42,295,870.60 |
| 35130 | Эм боох материал | 251,800.00 | 550,000.00 |
| 35400 | Хангамжийн материал | 54,680,063.43 | 55,329,391.05 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 761,000.00 | 706,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 39,269,729.43 | 47,222,913.05 |
| 35450 | Барилгын засварын материал | 6,948,330.00 | 3,379,550.00 |
| 35460 | Хүнсний материал | 7,701,004.00 | 4,020,928.00 |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)** | **274,106,381.97** | **618,177,409.87** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,039,497,933.76** | **1,084,473,146.50** |
| 39200 | Биет хөрөнгө | 1,007,544,513.76 | 1,052,519,726.50 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 904,089,647.24 | 901,988,439.47 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | (89,042,619.59) | (102,937,501.43) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 244,373,865.44 | 255,252,340.46 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | (116,897,540.78) | (77,374,501.37) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 94,030,647.73 | 77,952,797.89 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | (43,944,746.93) | (15,703,417.40) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,237,600.00 | 742,560.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө | (1,237,600.00) | (111,384.00) |
| 39217 | Номын фонд | 14,935,260.65 | 12,710,392.88 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 31,953,420.00 | 31,953,420.00 |
| 39301 | Программ хангамж | 4,369,420.00 | 4,369,420.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл – Программ хангамж | (440,000.00) | (440,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 28,024,000.00 | 28,024,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)** | **1,039,497,933.76** | **1,084,473,146.50** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)** | **1,313,604,315.73** | **1,702,650,556.37** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **15,512,400.00** | **296,800.00** |
| 41300 | Өглөг | 15,512,400.00 | 296,800.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 296,800.00 |
| 41311 | Цалингийн өглөг | - | 296,800.00 |
| 41360 | Бусад өглөг | 15,512,400.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 15,512,400.00 | - |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)** | **15,512,400.00** | **296,800.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,298,091,915.73** | **1,702,353,756.37** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 567,873,974.76 | 567,873,974.76 |
| 511001 | Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан | 567,873,974.76 | 567,873,974.76 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | (193,091,040.49) | 211,170,800.15 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (193,091,040.49) | (193,091,040.49) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 404,261,840.64 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 923,308,981.46 | 923,308,981.46 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)** | **1,298,091,915.73** | **1,702,353,756.37** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)** | **1,313,604,315.73** | **1,702,650,556.37** |

## 2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **13** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,138,511,600.00** | **1,518,488,700.00** |
| 1310 | Улсын төсвөөс | 1,029,583,400.00 | 1,390,696,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,029,583,400.00 | 1,390,696,900.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 108,928,200.00 | 127,791,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 108,928,200.00 | 127,791,800.00 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **159,509,006.80** | **134,904,271.37** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 159,509,006.80 | 134,904,271.37 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 25,151,230.00 | 6,258,096.60 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | - | 18,300.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 25,151,230.00 | 6,239,796.60 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 125,378,239.00 | 102,790,866.95 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал | 8,979,537.80 | 25,855,307.82 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,298,020,606.80** | **1,653,392,971.37** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,051,605,542.86** | **1,245,336,774.79** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,051,491,459.41 | 1,211,010,338.29 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 730,582,443.00 | 838,788,820.00 |
| 210101 | Үндсэн цалин | 519,805,009.00 | 537,587,084.00 |
| 210102 | Нэмэгдэл | 180,985,225.00 | 244,211,766.00 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | - | 27,480,000.00 |
| 210104 | Урамшуулал | 29,792,209.00 | 29,509,970.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 86,303,177.61 | 96,426,925.13 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,680,031.70 | 66,207,574.43 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,066,352.36 | 8,152,513.86 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,312,429.57 | 4,061,605.75 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,421,276.43 | 3,640,979.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,823,087.55 | 14,364,251.24 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 99,475,301.55 | 112,489,749.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,033,083.55 | 8,289,121.50 |
| 210302 | Түлш, халаалт | 91,442,218.00 | 103,394,628.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | 806,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,833,750.00 | 12,027,894.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,965,600.00 | 5,728,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,399,950.00 | 3,097,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,468,200.00 | 3,170,264.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 31,780.00 |
| 2105 | Нормативд зардал | 57,922,961.80 | 61,608,770.00 |
| 210502 | Хоол, хүнс | 57,922,961.80 | 61,608,770.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,032,700.00 | 12,840,530.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,032,700.00 | 12,840,530.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,481,384.40 | 10,698,826.39 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,481,384.40 | 10,698,826.39 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55,859,741.05 | 66,128,823.27 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,445,307.52 | 9,911,525.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 36,414,433.53 | 56,217,298.27 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 114,083.45 | 34,326,436.50 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 27,458,386.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 27,458,386.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 114,083.45 | 6,868,050.50 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 114,083.45 | 6,868,050.50 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **1,051,605,542.86** | **1,245,336,774.79** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **246,415,063.95** | **408,056,196.58** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | - | 3,794,355.94 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 3,794,355.94 |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | - | **3,794,355.94** |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | **246,415,063.95** | **404,261,840.64** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **13** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,138,511,600.00** | **1,518,488,700.00** |
| 1310 | Улсын төсвөөс | 1,029,583,400.00 | 1,390,696,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,029,583,400.00 | 1,390,696,900.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 108,928,200.00 | 127,791,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 108,928,200.00 | 127,791,800.00 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **24,535,230.00** | **6,258,096.60** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 24,535,230.00 | 6,258,096.60 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 24,535,230.00 | 6,258,096.60 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | - | 18,300.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 24,535,230.00 | 6,239,796.60 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,163,046,830.00** | **1,524,746,796.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,020,246,502.53** | **1,200,247,691.52** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,001,053,314.08 | 1,158,533,596.02 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 730,729,171.00 | 838,492,020.00 |
| 210101 | Үндсэн цалин | 509,805,009.00 | 537,587,084.00 |
| 210102 | Нэмэгдэл | 191,131,953.00 | 244,211,766.00 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | - | 27,480,000.00 |
| 210104 | Урамшуулал | 29,792,209.00 | 29,213,170.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 86,341,729.61 | 96,426,925.13 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,384,600.00 | 66,207,574.43 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,892,200.00 | 8,152,513.86 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,646,300.00 | 4,061,605.75 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,346,300.00 | 3,640,979.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,072,329.61 | 14,364,251.24 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 99,738,486.55 | 112,489,749.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,033,083.55 | 8,289,121.50 |
| 210302 | Түлш, халаалт | 91,705,403.00 | 103,394,628.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | 806,000.00 |
| 2105 | Нормативд зардал | 33,101,005.00 | 52,437,630.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,101,005.00 | 52,437,630.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,075,630.00 | 9,271,750.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,075,630.00 | 9,271,750.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,417,595.92 | 10,698,826.39 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,417,595.92 | 10,698,826.39 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,649,696.00 | 38,716,695.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,161,096.00 | 34,478,195.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,488,600.00 | 4,238,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 19,193,188.45 | 41,714,095.50 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 19,079,105.00 | 26,498,110.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 19,079,105.00 | 26,498,110.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 114,083.45 | 6,868,050.50 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 114,083.45 | 6,868,050.50 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 8,347,935.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 8,347,935.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)** | **1,020,246,502.53** | **1,200,247,691.52** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)** | **142,800,327.47** | **324,499,105.08** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **20,835,719.00** | **13,320,000.00** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 20,835,719.00 | 13,320,000.00 |
| 2251 | Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн | 20,835,719.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 20,835,719.00 | 13,320,000.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **20,835,719.00** | **13,320,000.00** |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)** | **(20,835,719.00)** | **(13,320,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)** | **121,964,608.47** | **311,179,105.08** |
| **14** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **78,325,219.67** | **200,289,828.14** |
| **15** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **200,289,828.14** | **511,468,933.22** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **567,873,974.76** | **923,308,981.46** | **(439,506,104.44)** | **1,051,676,851.78** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 246,415,063.95 | 246,415,063.95 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **567,873,974.76** | **923,308,981.46** | **(193,091,040.49)** | **1,298,091,915.73** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 404,261,840.64 | 404,261,840.64 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **567,873,974.76** | **923,308,981.46** | **211,170,800.15** | **1,702,353,756.37** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|
| **Татаас, санхүүжилтийн орлого** | **1,602,001,500.00** | **1,518,488,700.00** | **83,512,800.00** |
| Улсын төсвөөс | 1,474,209,700.00 | 1,390,696,900.00 | 83,512,800.00 |
| Орон нутгийн төсвөөс | 127,791,800.00 | 127,791,800.00 | - |
| **Бараа, үйлчилгээний орлого** | **9,320,000.00** | **6,258,096.60** | **3,061,903.40** |
| Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого | 9,320,000.00 | 6,258,096.60 | 3,061,903.40 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,611,321,500.00** | **1,524,746,796.60** | **86,574,703.40** |
| **Ажиллагчидтай холбогдсон зардал** | **1,317,910,800.00** | **934,918,945.13** | **382,991,854.87** |
| **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,171,476,300.00** | **838,492,020.00** | **332,984,280.00** |
| Цалин | 682,700,900.00 | 537,587,084.00 | 145,113,816.00 |
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | 488,775,400.00 | 300,904,936.00 | 187,870,464.00 |
| **Нийгмийн хамгааллын шимтгэл** | **146,434,500.00** | **96,426,925.13** | **50,007,574.87** |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 123,005,000.00 | 82,062,673.89 | 40,942,326.11 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 23,429,500.00 | 14,364,251.24 | 9,065,248.76 |
| **Бараа ,үйлчилгээний урсгал зардал** | **293,410,700.00** | **260,382,760.89** | **33,027,939.11** |
| **Тогтмол зардал** | **119,357,800.00** | **112,489,749.50** | **6,868,050.50** |
| Гэрэл цахилгааны зардал | 11,700,000.00 | 8,289,121.50 | 3,410,878.50 |
| Түлш, халаалтын зардал | 103,657,800.00 | 103,394,628.00 | 263,172.00 |

| | | | |
|---|---|---|---|
| Цэвэр, бохир усны зардал | 4,000,000.00 | 806,000.00 | 3,194,000.00 |
| **Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал** | **174,052,900.00** | **147,893,011.39** | **26,159,888.61** |
| Хоол | 55,163,500.00 | 52,437,630.00 | 2,725,870.00 |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 53,711,400.00 | 44,748,195.00 | 8,963,205.00 |
| Шуудан холбооны зардал | 14,852,400.00 | 10,698,826.39 | 4,153,573.61 |
| Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 5,763,900.00 | 4,238,500.00 | 1,525,400.00 |
| Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 70,000.00 | - | 70,000.00 |
| Урсгал засварын зардал | 10,434,000.00 | 9,271,750.00 | 1,162,250.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | | | - |
| Бусад /үдийн цай/ | 34,057,700.00 | 26,498,110.00 | 7,559,590.00 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 6,868,050.50 | (6,868,050.50) |
| **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **1,611,321,500.00** | **1,202,169,756.52** | **409,151,743.48** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 188,891,893.14 | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 511,468,933.22 | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,567.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 230.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 237.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,100.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд өвчтэй болон чөлөөтэй ажилчдын хоолны хөнгөлөлтийг илүү тооцож 230.0 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т (*төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*), 16 дугаар зүйлийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийг хөрөнгийг удирдах зарцуулалтад хяналт тавих*), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*), 13.6-т (*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*), 20 дугаар зүйлийн 20.2.5-т (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*) гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь : Цалинг илүү тооцож олгосон 230.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Албан шаардлага

Сургуулийн хүнсний материалын тайлангаас зарлагын баримт, хоолны ордерыг тулгаж шалгахад хоолны ордерт хүүхдийн тоо, өдрийн нормыг тэмдэглээгүй, өдрийн норм хэмжээнд засвар хийсэн, Засгийн газрын тогтоолд зааснаас 237.6 мянган төгрөгийн зөрүүтэй дүнгээр зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 13.6-т (*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*), Засгийн газрын 2025 оны 254 дугаар тогтоол 2-т (*Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6300 (зургаан мянга гурван зуу) төгрөгөөр, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6000 (зургаан мянга) төгрөгөөр тус тус тогтоосугай*) заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Хүнсний материалын тайланг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хөтөлж, хүүхдийн хоолны нэг өдрийн зардлыг батлагдсан нормын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

### 3.3 Зөвлөмж

1.Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт*: Дотоод сүлжээ сайжруулах зориулалтаар худалдан авсан 1,100.0 мянган төгрөгийн 4 ширхэг тоног төхөөрөмжийг аж ахуйн материалаар бүртгэж, хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т (*Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно*), 20 дугаар зүйлийн 20.2.3-т (*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*), 20.2.4-т (*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*), Сангийн сайдын 2025 оны А/3 тоот тушаалын хавсралтын 10 дугаар бүлгийн 10.1-т (*Үндсэн хөрөнгө нь бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслүүлэх, эсхүл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд нэгээс дээш жилээр ашиглагдах биет хөрөнгө юм*) гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Худалдан авсан хөрөнгийг дансны ангиллыг залруулан үндсэн хөрөнгөөр бүртгэж ажиллах.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 100 хувийг залруулагдаагүй алдаа ээлж байна. Нийт 1,567.6 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 1,567.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 10,885.7 мянган төгрөгөөр бага байгаа тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Дотоод сүлжээ сайжруулах зориулалтаар худалдан авсан 4 ширхэг тоног төхөөрөмжийг аж ахуйн материалаар бүртгэж, хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн байна . | 1 | 1,100.0 | - | - | - | - | 1 | 1,100.0 | - | - |
| Сургуулийн хүнсний материалын тайлангаас зарлагын баримт, хоолны ордерыг тулгаж шалгахад хоолны ордерт хүүхдийн тоо, өдрийн нормыг тэмдэглээгүй, өдрийн норм хэмжээнд засвар хийсэн, Засгийн газрын тогтоолд зааснаас зөрүү дүнгээр зарцуулсан зэрэг зөрчил илэрлээ. | 1 | 237.6 | - | - | 1 | 237.6 | - | - | - | - |
| Тайлант хугацаанд өвчтэй болон чөлөөтэй ажилчдын хоолны хөнгөлөлтийг илүү тооцож олгосон байна. | 1 | 230.0 | 1 | 230.0 | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **3** | **1,567.6** | **1** | **230.0** | **1** | **237.6** | **1** | **1,100.0** | **-** | **-** |